Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Боловсролын салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Амгалан Мөнх-Эрдэнэ

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх | | | | | | | |
| 1 | Боловсролын салбарын болон хяналт шалгалтын холбогдох хууль, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгөх, хяналт шалгалтын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 4 | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - Тухай бүр | - Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын ажилтны жишиг норм норматив батлуулах төсөлд санал өгсөн. - БШУ-ны сайдын 2024 оны А/127 дугаар тушаалын дагуу Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.4, 7.10, 7.11, 7.12 дахь заалт, 8.2 дугаар зүйлийн 6.14-т заасан зөвшөөрлийг олгоход хуульд заасан | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлага хангаж байгаа эсэхийг магадлан шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан баримт бичгийн бүрдүүлэлт болон системд оруулах байгууллагын мэдээлэл, мэргэжлийн багш, сургалтын орчин нөхцөл, сургалтын хэрэглэгдэхүүн, бусад холбогдох баримт бичгийг шаардлага хангуулан, үнэн зөв оруулах саналыг Мэргэжлийн болон техникийн боловсролын газарт хүргэсэн. Мөн энгийн зөвшөөрөл хүссэн 28 байгууллагын 68 хөтөлбөрийн 16 төрлийн баримт бичгийг нэг бүрчилэн нягтлан шалгаж, санал дүгнэлт өгсөн. | | |
| 2 | Нийслэл, орон нутагт их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 7 мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад | Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Албан шаардлагын хэрэгжилтийн хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) | Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 90,9% Албан шаардлагын хэрэгжилтийн хувь - 68% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - | Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь - 60% Албан шаардлагын хэрэгжилтийн хувь - 50% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - | Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02-р тогтоолоор батлагдсан Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 95%<br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөт шалгалт хийх ажлыг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах | | 72% | 65% | Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2025 оны 03-00/02 дугаартай Боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжаар аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын 5 байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдсэн. Хяналт шалгалтаар Хэнтий аймаг дахь политехник коллеж, Завхан аймаг дахь политехник коллеж, Говьсүмбэр аймаг дахь политехник коллеж, Багануур дүүрэгт байрлах "Гэрэлт ирээдүй" мэргэжлийн боловсролын сургуулиуд нь 03/6.1-3 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд дунд эрсдэлтэй, Сүхбаатар аймаг дахь политехник коллеж нь 54,2% буюу их | | үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрсдэлтэй үнэлэгдлээ. Дээрх политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургуулийн дотуур байрыг 03/6.1-6 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд Хэнтий, Завхан, Говьсүмбэр, Сүхбаатар аймаг дахь политехник коллежийн дотуур байрууд дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтад хамрагдсан зөрчилтэй байгууллагуудад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, илэрсэн зөрчилтэй холбогдуулан Сүхбаатар аймаг дахь политехник коллежид Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авлаа.<br>Хавсралт: 2 файл | | |
| 3 | Сүхбаатар, | Шалгалт хийсэн | - | Шалгалт хийсэн | Боловсролын яамны | 4-р сар, 5- | Өөрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Дундговь аймгийн боловсролын сургалтын байгууллагуудад нэгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | объектын гүйцэтгэлийн хувь Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) | | объектын гүйцэтгэлийн хувь - 65% (2) Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь - 60% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 45% | 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/18 дугаар удирдамжаар Сүхбаатар аймгийн зарим боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг боловсролын хяналтын чиглэлээр батлагдсан хяналтын хуудсуудад заасан асуудлын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын 5 сургуулийн үйл ажиллагааг 03/6.1-2 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж 68.9%, эрсдэл үүсэх магадлалын дундаж 28.1%-тай буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд бага-2, дунд-3, ерөнхий боловсролын 3 сургуулийн суралцагчдын дотуур | р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар | үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байрны үйл ажиллагааг 03/6.1-5 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж 73%, эрсдэл үүсэх магадлалын дундаж 25.9%-тай буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд бага-1, дунд-2 байна. Шалгалтад хамрагдсан хүүхдийн 5 цэцэрлэгийн үйл ажиллагааг 03/6.1-1 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж 76.4%, эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 23.9%-тай буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд бага-4, дунд-1 байна. Шалгалтад Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн үйл ажиллагааг 03/6.1-3 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж 47.4%, эрсдэл үүсэх магадлалын дундаж 54.2%-тай буюу | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрсдэл үүсэх магадлалын тухайд “их”, 03/6.1-6 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн дундаж 53.3%, эрсдэл үүсэх магадлалын дундаж 46.2%-тай буюу эрсдэл үүсэх магадлалын тухайд “дунд” байна. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 8 боловсролын сургалтын байгууллагад нийт 51 заалт бүхий улсын ахлах байцаагчийн хамтарсан албан шаардлага өгч, илэрсэн зөрчилтэй холбогдуулан Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуульд Зөрчлийн тухай хуулийн 9.11 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн 500,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа.<br>Хавсралт: 1 файл | | |
| 4 | Мэргэжлийн болон техникийн | Хяналт шалгалт хийсэн объектын | - | Хяналт шалгалт хийсэн объектын | Салбарын улсын Ерөнхий байцаагчийн | 4-р сар, 5-р сар, 6-р | Өөрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн шинэчлэн батлагдсан хууль, дүрэм журмын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх /холбогдох байгууллага, газартай хамтран/ | гүйцэтгэлийн хувь Илэрсэн зөрчил арилгалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) | | гүйцэтгэлийн хувь - 70% Илэрсэн зөрчил арилгалтын хувь - 65% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 50% | 2025 оны “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, хууль, дүрэм журмын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 03-00/19 дугаартай удирдамжаар Сүхбаатар, Архангай, Завхан аймгийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын 7 байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар зориулалтын бус барилга байгууламжтай, сургалт явуулж буй мэргэжил тус бүрээр стандартад нийцсэн дадлагын газаргүй, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, мэргэжлийн гарын авлага хүрэлцээгүй, мэргэжлийн бус | сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | багштай, эрэлттэй тэргүүлэх хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлээгүй, төгсөгчид ажил олгогчоос тавьж буй шаардлагыг хангаж буй эсэхэд чанарын судалгаа хийдэггүй, төгсөгчдийг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулдаггүй, дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулдаггүй зэрэг зөрчил дутагдлууд илэрч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 5 байгууллагад албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, зөрчилтэй холбогдуулан 3 байгууллагын 4 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 2,000,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа. Шалгалтын явцад ажилтнуудаа дарамталж, хууль бус үйлдэл гаргасан 1 албан тушаалтанд арга хэмжээ тооцуулахаар харьяалах дээд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шатны удирдах албан тушаалтанд санал хүргүүллээ. | | |
| 5 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь - 100% | Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь - 100% | 1.Боловсролын сайд, ТНБД-ын өгсөн үүрэг чиглэлийн дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн удирдамжаар Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт, дүрэм журмын боловсруулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, энгийн болон тусгай зөвшөөрөл олголт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд Төрийн захиргааны удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газартай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд шалгалт хийж, шалгалтын дүн танилцуулгыг удирдлагуудад | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 95%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулсан.<br>2.Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Ховд аймгийн Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн гаргасан шийдвэр, холбогдох баримт бичгийг шалган, тус аймгийн зарим цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагаас тайлбар тодруулга авч, шалгасан талаарх илтгэх хуудсыг гаргаж, Салбарын хяналтын газрын даргад танилцуулсан.<br>3.Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Сити их сургуулийн гоо сайхны тэмхимын багш нь суралцагчдаас удаа дараа бие даалт, шалгалтын төлбөр мөнгө хураасан гэх асуудалд Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2025 оны 03-00/13 удирдамжаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, анги дэвших шалгалтанд унасан, дахин шалгалтад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орохоор төлбөр төлсөн, ур чадварын тэмцээн зохион байгуулахаар нийтээр төлбөр хураасан асуудалд сургуулийн удирдлагад анхааруулж, сургуулийн эрх зүйн баримт бичигт тусгах, суралцагчдаас санал авах талаар зөвлөмж, чиглэл өгсөн. 4.Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2025 оны 03-00/04 дугаар удирдамжаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нартай хамтран СХД-т байрлах ерөнхий боловсролын “Өнөр” сургуулийн хичээлийн 3-р байрны нөхцөл байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, холбогдох байгууллагаас баримт бичгийг татан авч | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгасан. Хавсралт: 2 файл | | |
| 6 | Шилэн хяналтын цахим системийн боловсролын салбарын мэдээллийн санг хөтлөх, хяналт тавих, улсын байцаагчдыг удирдлага, арга зүйгээр ханган ажиллах | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн баяжуулалт (тоо) Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Хамрагдсан улсын байцаагчийн тоо | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн баяжуулалт (тоо) - 342 Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 6 Хамрагдсан улсын байцаагчийн тоо - 29 | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн баяжуулалт (тоо) - 250 Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 5 Хамрагдсан улсын байцаагчийн тоо - 29 | - Шилэн хяналтын цахим системийг хөтлөн, 2025 онд төлөвлөгөөт шалгалтад хамрагдах 355 объектыг нийслэл, орон нутгийн улсын байцаагч нар бүртгэн төлөвлөснийг объект бүрээр хянаж баталгаажуулсан. Нийслэл, орон нутгийн улсын байцаагч нарт хяналт шалгалтын мэдээллийг цахим системд үнэн зөв бүртгэх, авсан арга хэмжээ, мэдээллийг тодорхой оруулах, баталгаажуулах талаар тухай бүр зөвлөгөө чиглэл өгч байна. - Шинээр улсын байцаагчийн эрх авсан Сүхбаатар, Дундговь, Дархан-Уул аймгийн улсын байцаагч нарыг цахим системд бүртгэн, нэвтрэх эрхийг олгож, системд ажиллах талаар заавар зөвлөгөө өглөө. - Хяналт, үнэлгээний үндэсний хорооноос | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ирүүлсэн албан бичгийн дагуу хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор системийн шинэчлэл хийх ажлын даалгаврын төсөлтэй танилцан, шилэн хяналтын цахим системийг сайжруулах, ашиглахад хялбар болгох талаар санал хүргүүлсэн. | | |
| 3.1. Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана. | | | | | | | |
| 7 | Хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалт зохион байгуулах | Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Сургалт зохион байгуулсан тоо Хамрагдсан улсын байцаагч | Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 5 Сургалт зохион байгуулсан тоо - 1 Хамрагдсан улсын байцаагч - 60 | Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - Тухай бүр Сургалт зохион байгуулсан тоо - 1 Хамрагдсан улсын байцаагч - 30 | - Нийслэл, орон нутгийн улсын байцаагчдад мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудад хийгдэх төлөвлөгөөт шалгалт, мөн улсын хэмжээний 69 байгууллагад хийгдэх урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын талаар чиглэл өгсөн. Сүхбаатар аймгийн боловсролын хяналтын улсын байцаагчид хяналт | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгалтын баримт бичиг, шалгалт хийх арга, авах арга хэмжээний талаар заавар зөвлөгөө өглөө. - Улсын Ерөнхий Прокурорын газраас яам, нийслэлийн улсын байцаагч нарыг хамруулан зохион байгуулсан сургалтанд оролцон, хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэхдээ хэрхэн бүртгэх, хяналтын хуудас, бүрэлдэхүүн сонгох, удирдамжийг зөв оруулах талаар мэдээлэл өгсөн. | | |
| 8 | Салбарын хяналтын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | Мэдээллийн тоо | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. | - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах обьектын мэдээлэл, шинэчлэн батлагдсан хяналтын хуудасны мэдээллийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулсан. - Шилэн хяналтын цахим системийг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 85%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөтлөн, шалгалтад хамрагдсан байгууллагын шалгалтын мэдээлэл, хяналтын хуудасны мэдээллийг оруулсан. Шалгуулагч этгээд тоон гарын үсгээр нэвтрэн өөрийн байгууллагын мэдээллийг авах боломжтой юм. - Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг Боловсролын яамны цахим хуудсанд байршуулснаар аж ахуйн нэгж, байгууллага татан авч өөрсдийгөө үнэлэх боломжтой болсон.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.2. Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг | | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| төлөвшүүлнэ. | | | | | | | |
| 9 | Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг сар, улирлаар тайлагнах | Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна. Хэрэгжилтийн тухай бүр тайлагнасан байна. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө - 2 Тайлагналт - 14 | Гүйцэтгэлийн төлөвлөгөө - 1 Тайлагналт - 7 | Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Мөн хэрэгжилтийг тайлагнасан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 10 | Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь мэдүүлэх | Хуульд заасан хугацаанд мэдүүлсэн байна. | 1 | 1 | Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд буюу 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр гаргаж, мэдүүлсэн. | 1-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 11 | Төрийн албан хаагчийн чиг үүргийн хүрээнд хариуцаж шийдвэрлэсэн | Архивын баримтыг хүлээлгэн өгсөн байна. | Хүлээлгэн өгсөн архивын баримт - 0 | Хүлээлгэн өгсөн архивын баримт - 3 | Баримт бичгийг архивлахаар бэлтгэн, эмхэлж цэгцэлсэн. | 2-р сар | Өөрийн үнэлгээ: 80%<br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баримт бичгийг зохих хууль, журмын дагуу архивын баримт үүсгэн ТЗУГ-т хүлээлгэн өгөх | | | | | | үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |
| 12 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх | Өргөдөл, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | Шийдвэрлэлтийн хувь - 100% | Шийдвэрлэлтийн хувь - 100% | Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 41 албан бичиг, өргөдөл гомдол хүлээн авч, 19 өргөдөл гомдол, 16 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хариуг хүргүүлж, 6 албан бичиг, өргөдөл гомдол хугацаа болоогүй, шийдвэрлэлтийн шатанд явж байна. Шийдвэрлэлтийн талаар дурдвал: -Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Батзоригоос ирүүлсэн албан бичгийн дагуу нийслэлийн ерөнхий боловсролын “Өнөр” сургуульд хийсэн хяналт шалгалт, авсан арга хэмжээ, НБГ-аас холбогдох мэдээлэл, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөрчлийн хэргийн материал зэрэг 50 хуудас бүхий нотлох баримт бичгийг хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулан албан бичгээр хүргүүлсэн, - Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор системийн шинэчлэлт хийх ажлын даалгаврын төсөлд саналаа 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 11/1378 тоот албан бичгээр хүргүүлсэн, - Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу УИХ-ын 2024 оны 37 дугаар тогтоолын холбогдох заалтын биелэлтийг гарган, БНБТГ-ын шинжээчид хүргүүлсэн, - Иргэн Ц.Номунзулаас Баянзүрх дүүрэгт байрлах “Бяцхан анд” цэцэрлэгтэй холбогдуулан ирүүлсэн гомдлын дагуу НБГ-аас хийгдсэн хяналт | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгалт, авсан арга хэмжээ, болсон асуудлын талаар тодруулж, нягтлан шалгаж, иргэнд хариуг хүргүүлсэн, - МУ-ын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас ирүүлсэн албан бичгийн дагуу ерөнхий боловсролын "Өнөр" сургуульд хамтарсан хяналт шалгалт хийж, хариуг хүргүүлсэн, - Иргэн Б.Тэмүүлэнгээс 2025 оны 04 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд явагдсан монгол хэл, бичгийн шалгалтын зохион байгуулалт, агуулга, үнэлгээний талаар гомдол, санал ирүүлснийг Боловсролын үнэлгээний төв рүү уламжлан хүргүүлсэн. - Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу Завхан аймаг дахь политехник коллежид хамтарсан хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгч, албан тушаалтанд хариуцлага | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тооцуулахаар болсон. - Иргэний гомдлын дагуу Сити их сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, иргэнд хариу өгсөн. | | |
| 13 | Цаг үеийн нөхцөл шаардлага болон дээд шатны байгууллага, удирдлагаас өгсөн хууль ёсны шийдвэрийн дагуу ажил үйлчилгээг гүйцэтгэх | Цаг хугацаанд нь хийж хэрэгжүүлсэн байна. | Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100% | Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100% | 1.ТАЗ-ийн даргын баталсан 2025 оны 02 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд Ховд аймгийн Зэрэг, Манхан, Мөнххайрхан, Дуут, Чандмань, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Бигэр, Цогт, Эрдэнэ, Чандмань сум, Гуулин тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцан, хяналт шалгалт хийж, төрийн албан хаагчдын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баримт бичгийг үзэн, заавар зөвлөгөө, сургалт мэдээлэл өгч ажиллалаа. Нийт 22 боловсролын сургалтын байгууллагын 843 багш, ажилтны холбогдох баримт бичгийг үзэж шалган, танилцуулгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.<br>2.Боловсролын сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тогтоох, дүгнэлт гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, 15 дээд сургуулийн 2021-2022, 2022-2023, 2023-2024, 2024-2025 оны хичээлийн жилийн багш нарын мэдээллийг нотлох баримт бичигт тулгуурлан тулгалт хийж, нэгдсэн ажлын хэсэгт дүгнэлт саналаа хүргүүлсэн. 34 дээд сургуулийн удирдлагад танилцуулах, сонсох үйл ажиллагаанд 2025 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 05 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд оролцлоо. 3.БШУ-ны сайдын 2024 оны А/127 дугаар тушаалын дагуу Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.4, 7.10, 7.11, 7.12 дахь заалт, 8.2 дугаар зүйлийн 6.14-т заасан зөвшөөрлийг олгоход хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхийг магадлан шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын 29 байгууллагын 76 хөтөлбөрийн 16 төрлийн баримт бичгийг зөвшөөрлийн https://license.mn/ систем дээр магадлан шалгаж, дүгнэлт саналыг хүргүүлсэн. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 28 байгууллагын 68 хөтөлбөрт энгийн зөвшөөрөл олгох дүгнэлт, 5 хөтөлбөрт олгохгүй талаар, 1 хөтөлбөрийг буцаах, 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөтөлбөрийг цуцлах санал дүгнэлт гаргасан.<br>Хавсралт: 3 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, дүрэм журмын хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чадвараа дээшлүүлэх | Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг тухай бүр уншиж, судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. Мэргэжлийн чадвараа дээшлүүлнэ. | Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чадвар дээшилсэн. | Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чадвар дээшилсэн байна. | Монгол Улсын Ёс зүйн хорооноос Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш" бэлтгэх сургалтад 2025 оны 05 дугаар сарын 21, 22, 23-ны өдрүүдэд хамрагдаж, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх талаар | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдлэг мэдээлэл авч, хамтран багаар ажиллаж, харилцан туршлага солилцлоо.<br>Хавсралт: 1 файл | | |
| 2 | Мэдлэг, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдах | Яам болон холбогдох газруудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдана. | Албан хаагчийн мэргэжлийн ур чадвар дээшилсэн. | Албан хаагчийн мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна. | - Нийслэлийн Прокурорын газраас зохион байгуулсан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, түүнд анхаарах асуудал, харилцан мэдээлэл солилцох сургалтад 02 сард, мөн Улсын Ерөнхий Прокурорын газраас зохион байгуулсан "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-ийн хэрэглэгч нарт зориулсан сургалтад 2025 оны 05 сард тус тус хамрагдаж, системд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг бүртгэх, хөтлөх зэрэг мэдлэгийг олж авсан. - Төрийн захиргааны удирдлагын газраас зохион байгуулсан "Мэдээллийн цаг хөтөлбөрт тухай бүр хамрагдсан. Тухайлбал: "Юнайтед менежмент консалтинг- ХХК-ийн захирал Д.Ерөө "Ажлын байрны ёс зүй" сэдвээр, Стоклаб секьюритиз ҮЦК- | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХХК-ийн гүйцэтгэх захирал Е.Амарбат "Хөрөнгө оруулалт ба хөрөнгийн зах зээлийн тухай" сэдвээр, Монголын Хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Б.Дөлгөөн "Төрийн чадамжийг бүрдүүлэх нь" сэдвээр мэдээлэл хийснийг сонсож, мэдлэгээ дээшлүүлсэн. Хавсралт: 1 файл | | |
| 3 | Монгол хэлний тухай хуулийн дагуу Төрийн албан хэргийг 2025 оноос хос бичгээр хөтлөн явуулахаар болсонтой холбогдуулан монгол бичгийн чадвараа сайжруулах | Монгол бичгийн унших, бичих чадвараа бие даан сэргээн улам сайжруулах | Ерөнхий боловсролын сургууль, их сургуульд монгол бичгийн хичээл сурч байсан. | Монгол бичгийн унших, бичих чадвараа сайжруулсан байна. | Монгол бичгийн унших, бичих чадвараа бие даан сайжруулж байна. | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Боловсролын салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Амгалан Мөнх-Эрдэнэ /................................................./ Огноо: .........................